

БАТЛАВ.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Л.ЦЭДЭВСҮРЭН

2023 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХУДАЛДАН АВАХ "БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ"-ИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Тоног төхөөрөмж	Дараах техникийн үзүүлэлт хангасан (эсхүл түүнтэй дүйцэхүйц)	Тоо, ширхэг	Нэгж үнэ /мян.төг/	Нийт дүн /мян.төг/
<b>Багц-1: "Ерөнхий боловсролын сургуулийн багш ширээ, сандал, сурагч ширээ, сандал"</b>					
1	Багш ширээ	Багшийн ширээ нь цайвар шаргал өнгөтэй, хэмжээ: L1400мм x W750мм x H720мм. Багшийн ширээний тавцан, хөл, урд талын нүүр, шургуулга бүхий шүүгээг олон улсын E0, E1 стандарт хангасан, 18 мм-ийн зузаантай, нягт сайтай, модлог хавтангаар хийх бөгөөд хавтангийн хажуу хөвөөг өнгө дагуу 1.2мм-ээс доошгүй зузаантай PVC материалаар хийнэ. Ширээний эд ангиллын хоорондын угсралтыг тавилгын зориулалтын, далд холбоосны шурган хэрэгслээр хөдөлгөөнгүй бат бөх холбоно. Ширээний шургуулгыг баруун болон зүүн талд шилжүүлэн байрлуулах боломжтой хоёр шургуулга бүхий жижиг шүүгээтэй, ширээний эх биед хөдөлгөөнгүй бэхлэгдэж өлгөгдсөн байдалтай байна. Шургуулгууд нь шарик болон роликон хийц бүхий шулуун механизмгаар хөдөлгөөн хийгдэж, тус бүрдээ бариултай байна. Ширээний хөлөнд шалнаас хөндийрүүлсэн, зориулалтын зөөлөвч тогтоосон байна. Ширээний эд ангиуд нь задарч угсрагдах ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт дагалдах сэлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна. Ширээ нь угсралтын ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна.	70	650.0	45,500.0
2	Багш сандал	Багшийн сандал металл рамтай, түшлэгтэй, түшлэг болон суудал нь зөөлөвчтэй, хөл нь хуванцар хамгаалалттай, тохойвчгүй, сайн чанарын материалаар хийгдсэн, хар өнгөтэй байна. Хэмжээ L450мм x W450мм x H1-420мм-450мм x H2-900мм. Зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна.	70	90.0	6,300.0

3	<p>Бичиг хэргийн шүүгээний хэмжээ: L800мм x W400мм x H1900мм байх ба цайвар шаргал өнгөтэй байна. Шүүгээний дээд, дунд, хоёр хажуу хана, ёроол, хөл, хавтан хаалгыг олон улсын E0, E1 стандарт хангасан, 18 мм-ийн зузаантай, нягт сайтай, модлог хавтангаар хийх бөгөөд хавтангийн хажуу хөвөөг өнгө дагуу 1.2мм-ээс доошгүй зузаантай PVC материалаар хийнэ. Бичиг хэргийн шүүгээний дээд хэсэгт 3 тасалгаа бүхий 2 тавиуртай, тавиур хоорондын зай 400 мм-ээс багагүй байх бөгөөд нүүрэн хэсэгт металл рамтай 4мм зузаантай шилэн хийц бүхий 2 хаалгатай байна. Бичиг хэргийн шүүгээний доод хэсэгт дотороо тасалгаат тавцантай нүүрэн талдаа хавтан хийц бүхий 2 хаалгатай ба шилэн болон хавтан хаалгануудыг зориулалтын нугасаар их биед тогтоон угсарсан байна. Бичиг хэргийн шүүгээний эд ангиудын угсралтыг тавилгын зориулалтын, далд холбоосны шурган хэрэгслээр хөдөлгөөнгүй бөгөөд байхаар холбоно. Бичиг хэргийн шүүгээний шилэн болон хавтан хаалгууд нь тус бүрдээ бариул, нугас, дотор түржээ, далд цоож зэрэг тоноглол хэрэгслээс бүрдэнэ. Бичиг хэргийн шүүгээний хөлөнд шалнаас хендийрүүлсэн, зориулалтын зөөлөвч тогтоосон байна. Бичиг хэргийн шүүгээний эд ангиуд нь задалж угсрахад зориулсан ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт, дагалдах сэлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж, тээвэрлэх зориулалттай хамгаалалтын баглаа боодолтой байна.</p>	140	500.0	70,000.0
---	---	-----	-------	----------

4	<p>Ерөнхий боловсролын сургуулийн сурагч ширээ, сандлын иж бүрдэл /Нийт: ширээ-1062, сандал-2124/</p>	<p>"Сурагчийн ширээ ба сандал, техникийн шаардлага" MNS 6582:2016 стандартыг баримтална. Ширээний хэмжээг стандартын 2 дугаар хүснэгтэд заасны дагуу хийнэ. Сурагчийн ширээний тавцан болон нүүрний хэсгийг олон улсын E0, E1 стандарт хангасан бөгөөд MNS 6582:2016 стандартын 6.3.3-д заасан материалаар хийнэ. Ширээний тавцан, хөлийг боолтоор холбохдоо тавцангийн дээд талд боолтны толгой ил гаргахгүй. Ширээний булангууд нь 10мм-30мм дугуй байна. Ширээний тавцанг модлог хавтангаар хийвэл хөвөөг өнгө дагуу 1.2мм-ээс доошгүй зузаантай PVC материалаар хийнэ. Ширээний хөлийг 1.5-2мм зузаан металлээр хийж, хүүхдэд сөрөг нөлөөгүй, хуулардаггүй төмрийн будгаар шүршиж будсан байна. Тавцан шаргал өнгөтэй, ширээний хөл цагаан саарал өнгөтэй байна. Хөлийн хуванцар хамгаалагч нь шал урахгүй, зураас гаргахгүй, хагарахгүй материалаар хийгдсэн байна. Ширээ нь тогтвортой баг бөх байна. Ширээний өндөр намыг тохируулах боломжтой байна /Тохируулгын зайг стандартын 3 дугаар хүснэгтэд заасны дагуу хийнэ/, Ширээг өндөр нам болгох холбогч нь задлах, угсрахад хялбар байх бөгөөд найдвартай байна. Сурагчийн ширээ нь тавиуртай байх ба ширээг хийсэн үндсэн материалаар хийнэ. Ширээ нь угсралтын ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна.</p> <p>Сандлын суудал болон арын түшлэгийг стандартын 7.3.8-д заасан материалаар хийнэ. Суудал болон түшлэг хэсгийн булангууд 10мм-30мм дугуй байна. Суудлын урд ирмэг хэсэг 20-50мм маталттай, хурц ирмэггүй байна. Сандлын хөлийг 1.5-2мм зузаан металлээр хийж, хүүхдэд сөрөг нөлөөгүй, хуулардаггүй төмрийн будгаар шүршиж будсан байна. Сандлын тавцан, түшлэг шөргөл өнгөтэй, сандлын хөл цагаан саарал өнгөтэй байна. Хөлийн хуванцар хамгаалагч нь шал урахгүй, зураас гаргахгүй, хагарахгүй материалаар хийгдсэн байна. Сандал нь тогтвортой, баг бөх байна. Суудлыг өндөр, нам болгох тохируулагчтай байна. /Тохируулгын зайг стандартын 6 дугаар хүснэгтэд заасны дагуу хийнэ/, Сандлын өндрийг тохируулахдаа хөлийг салгаж, угсарч хийдэг байж болно. Тохируулагч нь хялбар бөгөөд найдвартай түгжигддэг байна. Сандал нь угсралтын ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна.</p>	1,260	505.0	636,300.0
5	Ангийн самбар	<p>Самбарын хэмжээ: L3000мм x H1200мм ба их биеийн материал 20мм-ийн зузаантай байна. Самбар нь тод ногоон /баталгаат хугацаанд* самбарын ногоон өнгө нь цайрч бүдгэрэхгүй байх/ болон цагаан өнгөтэй байна. Хичээлийн самбар нь хананд өлгөгддөг нэг тал нь ногоон өнгөтэй шохойгоор бичдэг нөгөө тал нь цагаан өнгөтэй самбарын үзгээр /маркераар/ бичих боломжтой цайрдмал сайн чанарын хөнгөн цагаан рамтай байх бөгөөд бичгийн хэрэгсэл тогтоох соронзон гадаргуу бүхий хальсан хамгаалалтай, бичгийн хэрэгсэлүүд тавих жижиг хэмжээний тавиуртай, чийглэг өнгөлгөөг даах арчиж цэвэрлэхэд хялбар, 2 талаар нь өлгөж ашиглах боломжтой, бичих талбай нь залгаагүй, нэгэн жигд байна. Ханын самбар нь угсрагдах ажлын зураг, иж бүрдлийн жагсаалт, дагалдах сэлбэг хэрэгсэл болон зөөвөрлөж тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын баглаа боодолтой байна.</p>	70	557.0	38,990.0
	ДҮН	1,610		797,090.0	

Багц-2: "Сургуулийн өмнөх болговсролын байгууллагын гал тогооны тоног төхөөрөмж"

**Багц-2-1: "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гал тогооны тоног төхөөрөмж" /дотоодын үйлдвэрээс худалдан авах/**

1	Бэлтгэлийн ширээ	Зэвэрдэггүй, хүнс бэлтгэх зориулалтын гангаар хийгдсэн байх (хүнснэй шууд харьцах гангийн марк AISI304). Хэмжээ: урт 1500 мм, өргөн 600мм, өндөр 860 мм. Ширээний нийт жин 70-80 кг, ширээний тавцангийн ачаалал даах жин буюу тавцангийн даац 50-60кг байна. Тавцанг хотойхоос хамгаалсан шахмал модон давхар тавцантай, тавцангийн зузаан 18мм-ээс доошгүй	20	900.0	18,000.0
2	Цахилгаан пийшин	Материал: зэвэрдэггүй ган, Ширэмний тоо: 4, Ширэмний хэмжээ: 295x417мм, Хүчдэл: 380В, 50Гц, Чадал: 17.0 кВт, Хэмжээ: 1050x895x860мм, Шарах шүүгээний доторх хэмжээ: 538x535x290мм, Шарах шүүгээний дотор талын гадаргуу нь паалан, Шарах шүүгээ нь 3 листтэй, лист нь паалан, температурын тохируулга: 0°C...+300°C хүртэл, Монгол улсын үндэсний	10	3,200.0	32,000.0
3	Жигнүүр	Бууз, мантуу, ногоо жигнэх, будаа агшаах зориулалттай, Материал: зэвэрдэггүй ган, Гангийн зузаан: 1мм, Гаднаа температур заагчтай, 4 дугуйтай, 6 тавиуртай, Хүчдэл: 380В, 50Гц, Чадал: 6кВт, Хэмжээ: 650x500x1100мм, Монгол улсын үндэсний тохирлын гэрчилгээтэй байна.	9	860.0	7,740.0
			39		57,740.0

**Багц-2-2: "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гал тогооны тоног төхөөрөмж" /импортын бүтээгдэхүүн/**

1	Будаа агшаагч	Нийтийн хоолны зориулалттай, хүчдэл: 220В, Чадал: 3.9кВт, Багтаамж: 30 л, түлж наалдуулахаас хамгаалсан тусгай дөвхөргөтэй, Монгол улсын үндэсний тохирлын болон нийтийн хоолны салбарт ашиглахыг зөвшөөрсөн гэрчилгээтэй, ISO 9001:2015 хангасан байна.	19	585.0	11,115.0
2	Хөргөгч*	Гадна тал зэвэрдэггүй гангаар хийгдсэн, битүүмжлэл сайтай резинтэй, Хэмжээ:1220*760*1980мм, Багтаамж:1000л, 4 хаалгатай, тус тусдаа тасалгатай, тасалгаа тус бүрд 2 тавиуртай, 4 дугуйтай, температурын тохируулгатай, Хүчдэл : 220В, 50°ц, Монгол улсын үндэсний тохирлын гэрчилгээтэй байна.	20	3,300.0	66,000.0
3	Дээжийн хөргөгч	Хоолны дээж хадгалах зориулалттай, шилэн хаалгатай, Багтаамж 70л, 9°С-12°С. Хүчдэл 220В, Хэмжээ: 440*430*660мм, 50 Гц, түүнтэй дүйцэх, Монгол улсын үндэсний тохирлын гэрчилгээтэй байна.	20	600.0	12,000.0
7	Цахилгаан махны машин	Цагт 80 кг-аас багагүй мах машиндах чадалтай, зэвэрдэггүй ган (AISI304)-гаар хийсэн. Хүчдэл 220В, 50 Гц, Чадал 0.5 кВт, 2 хутга 3 шүүртэй, шүүрний хэмжээ: I - 3 мм, II - 5 мм, III - 9 мм. ISO 9001:2015 стандартын шаардлага хангасан байна.	20	2,800.0	56,000.0
			79		145,115.0
					999,945.0

Хянасан:

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Боловсруулсан:

Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

О.Хуяцогт

С.Нансалмаа

Б.Түмэнбаяр



ДҮН

Нийт дүн